

**“ХЭВЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН  
ТӨГСГӨЛИЙН ШАТНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017 оны 3 дугаар сарын 31

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл																				
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр:  “Хэвлэлийн үйлдвэрлэл” хөтөлбөр /2008-2016/ Засгийн газрын 2008-02-13-ны өдрийн 53 дугаар тогтоол.	<b>Хөтөлбөрийн зорилго:</b> Хэвлэлийн үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцлийг бүрдүүлж, үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэхэд оршино. ➤ Үйлдвэр, худалдааны Сайдын 2008 оны 81 тоот тушаалаар “Хэвлэлийн үйлдвэрлэл” хөтөлбөрийн 1-р үе шатны зорилтын хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг, ➤ Үйлдвэр, хөдөө аж ахуйн Сайдын 2013-05-02-ны өдрийн А/59 тоот тушаалаар 2-р шатны /2013-2016 он/ зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталан хэрэгжүүлсэн байна.																				
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> <li>• Улс, орон нутгийн төсөв,</li> <li>• хөнгөлөлттэй зээл,</li> <li>• олон улсын гадаад дотоодын зээл тусламж,</li> <li>• аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө</li> </ul>																				
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<b>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага:</b> ХХААХҮЯ, ҮХААЯ, АҮЯ, Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоо I үе шат 2008-2012, II үе шат 2013-2016, нийт 8 жил <b>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:</b> БСШУЯ, Хөдөлмөрийн яам, СХЗҮТөв																				
4	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<b>Зорилт 1.</b> Хэвлэлийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, зохицуулах эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх; <b>Зорилт 2.</b> Хэвлэлийн үйлдвэрлэлд импортын бүтээгдэхүүн, түүхий эдийг орлуулах дотоодын үйлдвэрлэлийг өргөжүүлэх; <b>Зорилт 3.</b> Шинэ дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухаан, технологийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэх; <b>Зорилт 4.</b> Орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх; <b>Зорилт 5.</b> Хэвлэлийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах;																				
5.	Зардал  Төсөв (Нийт шаардагдах зардал)	<p><b>1-р шат:</b> Хөтөлбөрийн /2008-2012/ зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Үйлдвэр, худалдааны сайдын 2008 оны 81 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан.</p> <p>➤ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 1 дүгээр шатны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 14 арга хэмжээг төлөвлөн, улсын төсвөөс <b>300 сая</b>, олон улсын зээл тусламжаар <b>300 сая</b>, хөнгөлөлттэй зээлээр <b>35170,0 сая</b> төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.</p> <p><b>2-р шат:</b> “Хэвлэлийн үйлдвэрлэл” хөтөлбөрийн 2-р үе шатны төлөвлөгөөг Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоотой хамтран боловсруулж, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2013 оны А/59 тоот тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>➤ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2-р үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд улсын төсвийн хөрөнгөөр <b>180.0 сая</b>, хөнгөлөлттэй зээл, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр <b>93400.0 сая</b>, олон улсын зээл тусламжаар <b>400.0 сая</b>, нийт <b>103980,0</b> төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөсөн.</p> <p align="center"><i>Улсын төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хүснэгтэд тусган харуулав.</i></p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Үе шат</th> <th>Төсөв, сая/төг (он)</th> <th>Гүйцэтгэл, сая/төг</th> <th>Хувь, %</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>2009-2012</td> <td>300,0</td> <td>65,0</td> <td>21,6</td> </tr> <tr> <td>2</td> <td>2013-2016</td> <td>180,0</td> <td>10,0</td> <td>5,5</td> </tr> <tr> <td></td> <td>ДҮН</td> <td><b>480 сая</b></td> <td><b>75 сая</b></td> <td><b>15,6</b></td> </tr> </tbody> </table> <p>✓ Нийт улсын төсвөөс санхүүжүүлэх арга хэмжээний 480,0 сая төг төсөвлөсөн боловч 75 сая буюу 15,6% санхүүжилтийг авсан байна.</p>	№	Үе шат	Төсөв, сая/төг (он)	Гүйцэтгэл, сая/төг	Хувь, %	1	2009-2012	300,0	65,0	21,6	2	2013-2016	180,0	10,0	5,5		ДҮН	<b>480 сая</b>	<b>75 сая</b>	<b>15,6</b>
№	Үе шат	Төсөв, сая/төг (он)	Гүйцэтгэл, сая/төг	Хувь, %																		
1	2009-2012	300,0	65,0	21,6																		
2	2013-2016	180,0	10,0	5,5																		
	ДҮН	<b>480 сая</b>	<b>75 сая</b>	<b>15,6</b>																		

6.	<p>Төсөл, хөтөлбөрийн зорилт:</p> <p><b>1-р зорилт</b> <i>Хэвлэлийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, зохицуулах эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх</i></p> <p><b>Хүрэх үр дүн:</b> <i>Хууль эрх зүйн таатай орчин бүрдсэн байх</i></p>	<p>Нийт 5 зорилттой.</p> <p><b>1.1. Хэвлэлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж боловсруулах;</b></p> <p>❖ Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт нийт 38 хууль, УИХ болон ЗГ-ын 8 тогтоол мөрдөгдөж байгаагаас хамгийн чухал нөлөөлтэй эерэг үр дүнг үзүүлсэн нь Засгийн газрын 2014 оны 18-р тогтоолоор баталсан Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай, Засгийн газрын 2012 оны 100-р тогтоол, 2014 оны 191-р тогтоол “Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай”, 2015 оны 336-р тогтоол “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт батлах тухай” зэрэг болно. Дээрх хууль, тогтоомжийн хүрээнд төсөв хөрөнгө ихээр шаардахгүй ажил үйлчилгээ арга хэмжээ явуулсны үр дүнд үндсэндээ хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын хөгжил, бие даасан байдал эрс нэмэгдсэн бөгөөд эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд ч харьцангуй дархлаатай болсон байна.</p> <p>❖ Цаашид УИХ-ын 2016 оны 62-р тогтоолоор баталсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, УИХ-ын 2016 оны 45-р тогтоолоор баталсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, УИХ-ын 2016 оны 19-р тогтоолоор баталсан Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 зэрэг хууль, эрх зүйн хүрээнд ажил хийгдэх болно.</p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” Засгийн газрын 2012 оны 100, 2014 оны 191-р тогтоолоор баталсан жагсаалтад хэвлэлийн салбарын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг хамруулан тусгуулсан. Мөн шинэчлэн батлах тоног төхөөрөмжийн жагсаалтыг тайлбарын хамт гаргаж, саналаа тухай бүр хүргүүлэн ажиллав.</p> <p>❖ Дотооддоо үйлдвэрлэж байгаа хөнгөн үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний импортын татварыг шинэчлэх төсөлд ном, сонин, зурагт хуудас ба бусад хэвлэмэл бүтээгдэхүүний импортын татварыг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэх санал шинэчлэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн ч эдийн засгийн хүндрэлээс хамааралтай түр хойшлуулах шийдвэр гарсан болно.</p> <p>❖ УИХ-ын 2016 оны 62-р тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын хүрээнд импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бүс, орон зайн горимыг тодорхойлох, үйлдвэрүүдийн байршил, тогтоох, нэгдсэн төлөвлөлт, зураглал боловсруулахад хэвлэлийн салбарын мэдээллийн сан тогтолцоог бий болгох, “нэгдсэн төлөвлөлт зураглал” гаргах төлөвлөлтийн дагуу хэвлэлийн үйлдвэрийн байршлын зураглал гаргаж, мэдээллийн нэгдсэн санд шаардлагатай бүх материалыг бүрдүүлж, үндэслэл, тооцоог хийж, тойм зураглалыг гаргуулан ажилласан байна.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ: 100</b></p> <p><b>1.2. Үйлдвэрлэлийн болон бүтээгдэхүүний стандарт, техникийн нөхцөлийг боловсруулах, шинэчлэн батлуулах;</b></p> <p>❖ Засгийн газрын 2015 оны <b>336-р</b> тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-д бүх төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүн: ном, товхимол, газрын зураг, ухуулга сурталчилгааны хуудас болон тэдгээртэй төстэй хэвлэмэл материал, сонин, сэтгүүл болон тогтмол хэвлэл, ном, зургийн буюу будах зориулалттай хүүхдийн ном, хэвлэмэл буюу зурагтай ил захидал, баярын мэндчилгээ,</p>
----	--	---

	<p>зарлал, мэдээлэл бүхий хэвлэмэл хуудас, бүх төрлийн хэвлэмэл хуанли, сурах бичиг, сургалтын болон төсвийн байгууллагын бүх төрлийн хэвлүүлэх материалыг оруулсан.</p> <p>❖ Өндөр хөгжилтэй хэвлэлийн үйлдвэрлэлийн стандартыг орчуулах, зарим шаардлагатай үндэсний стандартуудыг боловсруулах ажлын хэсгийг мэргэжлийн холбоотой хамтран байгуулж, стандартуудын нэр томъёо, үг хэллэгийг нэг мөр тогтоох хэлэлцүүлгийг хийж <b>“Хэвлэлийн салбарын нэр томъёоны стандарт”</b>-ыг монгол, орос, англи, герман, франц хэл дээр, ОХУ, Япон, Германы хэвлэлийн хуулийг орчуулуулав.</p> <p>❖ Мөн хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага, хэвлэлийн ерөнхий нэр томъёо, сэтгүүл, сонин, хэвлэлийн эхэд тавигдах ерөнхий шаардлага, цаас, хэвлэлийн шинжийг тодорхойлох зэрэг стандартуудын төслийг боловсруулан Стандартчилалын дэд хорооны хурлаар хэлэлцүүлэхээр 2015 онд хүргүүлсэн байна.</p> <p>❖ Үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх тогтоолын үйлчлэх хугацааг 2016 он дуустал сунгахад тус салбарын тоног төхөөрөмжүүд нэмэлтээр шинэчэн хамруулсан.</p> <p>❖ ЗГ-ын 336-р тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Жижиг дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн хэвлэлийн үйлдвэрийн зориулалттай 35 нэрийн 42 тоног төхөөрөмж, /БТКУС код: 8442-90.33.00/ цаасны үйлдвэрийн 2 нэрийн/ 84.39-42/, сав баглаа боодлын 15 нэрийн 23 төрлийн тоног төхөөрөмж нийт 52 нэрийн 67 төрлийн тоног төхөөрөмжид хөнгөлөлтийн жагсаалтад оруулахаар ЖДҮХБХГ-т тайлбарын хамт хүргүүлэв.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ:100</i></p> <p><b>1.3. Хэвлэлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төсвийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаанд салбарын мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх ;</b></p> <p>✓ Засгийн газрын 2011-04-06-ны өдрийн 103-р тогтоолд тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд худалдан авахдаа тэргүүн ээлжинд дотоодын үйлдвэрүүдээс худалдан авах бараа, бүтээгдэхүүний жагсаалтанд бүх төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүн, сурах бичиг, сургалтын болон төсвийн байгууллагын бүх төрлийн хэвлүүлэх материал, төсвийн байгууллагуудын бичиг хэргийн хэрэгсэл, цаас, дотоодод үйлдвэрлэдэг бусад материалуудыг оруулан батлуулсан. Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоотой хамтран БСШУЯ-ны холбогдох албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулж, хэрэгжилтийг хангах ажлуудыг зохион байгуулан ажиллав.</p> <p>✓ Жил бүр БСШУЯ-аас зарласан сурах бичгийн тендерт Мөнхийн үсэг” ХХК, “Сэлэнгэ прэсс”ХХК, “Адмон”ХХК,” Улаанбаатар принт”ХХК,”Соёмбо принт” ХХК,”БИ СИ АЙ”ХХК,”Ном хур”ХХК, “Сод прэсс”ХХК зэрэг 7-9 аж ахуйн нэгж оролцож шалгаран дунджаар 450-650 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Төрийн болон төрийн өмчит үйлдвэрийн газруудын дэргэдэх хэвлэлийн цех, жижиг 12 үйлдвэрүүдийн жагсаалт гаргаж, 2015 онд Аа үйлдвэрийн Сайдын албан тоотоор мэдэгдэл хүргүүлсэн. Сонгон шарлгаруулалтанд оролцогч компаниудын талаарх мэдээлэл, тодорхойлолтыг тус яамнаас гаргаж хүргүүлж байна.</p> <p>✓ Дотоодын үйлдвэрлэгчид борлуулагчдыг дэмжих чиглэлээр</p>
--	--

		<p>2016 онд нэгдсэн зөвлөгөөн хийж, АУЯ, БСШУЯ хооронд санамж бичиг байгуулсан бөгөөд уг санамж бичигт тэргүүн ээлжинд дотоодын үйлдвэрлэгчдээс ном, сурах бичиг, төрийн албаны маягт, үнэт цаасан хэвлэлээс худалдан авалт хийх, сонгон шалгаруулалтыг журмын дагуу явуулахаар тусгасан.</p> <p>✓ Салбарын мэргэжлийн оролцоог дэмжих зорилгоор Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоотой хамтран сурах бичиг, ном, үнэт цаасан хэвлэлийн сонгон шалгаруулалтанд оролцогч үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн талаархи тодорхойлолт, санхүү болон техникийн хүчин чадлын талаарх мэдээлэл жил бүр гаргаж зохих газруудад хүргүүлж байна.</p> <p>✓ Засгийн газрын 2015-08-17-ны 336 дугаар тогтоолоор Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтыг баталж, уг жагсаалтад заасан барааг нийлүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж, жил бүрийн худалдан авахаар төсвийн ерөнхийлөгч нарт үүрэг болгосон.</p> <p>✓ Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай” саналыг боловсруулж, Засгийн газрын 2016-09-28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж Засгийн газрын гишүүдэд болон төсвийн Ерөнхийлөн захирагч нарт хуралдааны 48 дугаар тэмдэглэлээр үүрэг өгөгдсөн. Энэ үүргийн дагуу 2016-09-28-ны өдөр “Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих талаар ард иргэд, аж ахуйн нэгж байгууллага, бүх шатны төсвийн байгууллагад хандсан уриалга гаргаж олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж ажиллав.</p> <p style="text-align: center;"><i>Дотоодын үйлдвэрээс худалдан авсан хэвлэлийн бараа /2015/</i></p> <table border="1" data-bbox="614 1041 1484 1160"> <thead> <tr> <th>№</th> <th>Худалдан авсан барааны төрөл</th> <th>Мөнгөн дүнгээр /мян.төг./</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Бүх төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүн</td> <td>2,267,777.69</td> </tr> <tr> <td>2</td> <td>Сав баглаа боодол бэлэг дурсгалын зүйл</td> <td>77,296.8</td> </tr> <tr> <td></td> <td><b>Нийт</b></td> <td><b>2,345,074.49</b></td> </tr> </tbody> </table> <p><i>Мэдээллийн эх үүсвэр: ХөУБХЗГазар</i></p> <p>❖ Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг 2016-10-20-24 ны өдрүүдэд Мишээл экспо үзэсгэлэнгийн танхимд Арьс шир, ноос ноолуур, хэвлэлийн холбоод хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд нийт 156 аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчид 531 сая төгрөгийн борлуулалт хийж, загварын шоу зохион байгуулж, шилдэгийн шилдэг бүтээгдэхүүн, үйлдвэрлэгчид, нэр төрлийг шалгаруулав.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:100</b></p>	№	Худалдан авсан барааны төрөл	Мөнгөн дүнгээр /мян.төг./	1	Бүх төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүн	2,267,777.69	2	Сав баглаа боодол бэлэг дурсгалын зүйл	77,296.8		<b>Нийт</b>	<b>2,345,074.49</b>
№	Худалдан авсан барааны төрөл	Мөнгөн дүнгээр /мян.төг./												
1	Бүх төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүн	2,267,777.69												
2	Сав баглаа боодол бэлэг дурсгалын зүйл	77,296.8												
	<b>Нийт</b>	<b>2,345,074.49</b>												
	<p><b><u>2-р зорилт:</u></b> Хэвлэлийн үйлдвэрлэлд импортын бүтээгдэхүүн, түүхий эдийг орлуулах дотоод үйлдвэрлэлийг өргөжүүлэх;</p> <p><b><u>Хүрэх үр дүн:</u></b> Хэвлэмэл бүтээгдэхүүнийг дотооддоо 100 % үйлдвэрлэн улмаар экспортод гаргана.</p>	<p><b>2.1. Дотоодын түүхий эдэд түшиглэн цаасны үйлдвэр байгуулах судалгаа хийж техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах</b></p> <p>❖ УИХ-ын 2015 оны 62-р тогтоолоор батлагдсан “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн дунд хугацааны стратеги”-т экспортын баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд цаасны үйлдвэрийг байгуулах талаар судалгаа хийгдэж, манай орны нөхцөлд модны целлойд ашиглан цаасны үйлдвэрийг байгуулах нь хүндрэлтэй, байгаль экологид сөрөг нөлөөтэй, харин хаягдал цаасыг ашиглан цаасны үйлдвэр байгуулах боломжтой, манайд ургах чадвартай мод, сүрэл тарьж, цаасны түүхий эдийг бэлтгэх үйлдвэр байгуулах боломжийг судлан хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэж үзсэн.</p> <p>❖ 2016 онд Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийн чулууны хаягдлаар цаас үйлдвэрлэх технологи туршилтыг БНХАУ, Герман улсын мэргэжилтнүүдтэй хамтран хийж амжилттай болсон боловч, эцсийн үр ашгийн тооцоолол өндөр байсан учраас цаашид авах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй болно</p> <p>❖ Монголд цаасны үйлдвэрлэл байгуулах, түүний үр өгөөжийн</p>												

	<p>талаар мэргэжлийн холбоо, үйлвэрлэгчидтэй хэлэлцүүлэг зохион байгуулж, санал асуулга явуулахад цаасны үйлдвэр байгуулах нь ашиггүй, харин туслах материал, будаг хэрэгсэлийн бага жижиг үйлдвэр байгуулах нь зүйтэй гэсэн дүгнэлт нь гарч байна.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 70</i></p> <p><b>2.2. Хэвлэлийн үйлдвэрлэлд өргөн хэрэглэгддэг үндсэн болон туслах материалын үйлдвэр байгуулах төслийг хөнгөлөлттэй зээлд хамруулах;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Жилд дунджаар 120-130 тэрбум төгрөгийн цаасыг гаднаас импортоор оруулж ирж байгаа учир импортыг бууруулах чиглэлээр хаягдал цаасны үйлдвэр байгуулах 9,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд төсөл хэрэгжүүлэхээр Азийн хөгжлийн банкад 2016 онд санал хүргүүлсэн байгаа.</li> <li>❖ Монголд цаасны үйлдвэрлэл байгуулах, түүний үр өгөөжийн талаар мэргэжлийн холбоо, үйлвэрлэгчидтэй хэлэлцүүлэг явуулахад цаасны үйлдвэр байгуулах нь ашиггүй харин туслах материал, будаг хэрэгсэлийн бага жижиг үйлдвэр байгуулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарч үйлдвэржүүлэх хөтөлбөрт тусгуулаад байна.</li> <li>❖ Сонин болон номын зориулалттай 2-р цаасаар үйлдвэрлэгдэж буй бүтээгдэхүүний үр ашгийн тооцооллыг хийж, хэвлэмэл бүтээгдэхүүний технологийн лаборатори байгуулахаар уг төслийн 2-р шатанд төсөвлөсөн боловч, санхүүжилт хүрэлцээгүйн улмаас хойшлогдсон бөгөөд АЗХ-ийн банкны хүрээнд 500 сая төгрөгийн санхүүжилтээр төсөл хэрэгжүүлэхээр санал тавьсан байна.</li> <li>❖ Хэвлэлийн үйлдвэр технологийн паркийн байгуулах үндэслэл, судалгаа хийхээр 20,0 сая төгрөгийг 2018 оны улсын төсөвт тусгуулсан.</li> <li>❖ 2014 онд ашиглалтанд орсон “Сайн цаас”ХХК-ны сонингийн цаасан үйлдвэрлэл 2017 оны эхээр анхны бүтээгдэхүүнээ гаргахаар технологи шинэчлэл хийж, эхний бүтээгдэхүүнээ гаргасан байна.</li> <li>❖ Нийслэлийн зураг төслийн хүрээлэнд хэвлэлийн үйлдвэр технологийн паркийн зураг төсөл хийлгүүлэхээр 2015 онд албан хүсэлт хүргүүлсэн байна.</li> <li>❖ Ариун цэврийн цаасны 4 үйлдвэрийн “Өд” “Ариун”, “Фин пак” зэрэг ахуйн хэрэглээний цаас үйлдвэрлэл, хаягдал цаас дахин боловсруулах “Эко монгол Пак” цаасан хайрцагны үйлдвэрлэл, дахин боловсруулах “Сайн цаас”ХХК картон цаасны үйлдвэрлэл ашиглалтанд орж, улмаар сонин болон номын 2-р цаасны хэрэгцээг хангах чиглэлээр ажиллаж байна.</li> </ul> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 70</i></p> <p><b>2.3. Байгаль орчинд халгүй, дэлхийн жишигт нийцсэн сав, баглаа боодол, шошгоны үйлдвэрийг байгуулахад техникийн тусламж үзүүлэх санхүүжүүлэгчийг олох;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ “Мөнхийн үсэг” групп 2010 онд сав баглаа боодлын “Эко Пак Монгол”ХХК 600 орчим сая төгрөгийн хөнгөлттэй зээлээр хоногт 80-100 мянган ш хайрцаг үйлдвэрлэх хүчин чадалтай, шинэ технолги бүхий хүний биед хоргүй эко үйлдвэр дотоодын зах зээлд 30 орчим нэр төрлийн савлагааны бүтээгдэхүүн нийлүүлж сардаа 50-60 сая төгрөг үйлдвэрлэл явуулж, 70-100 ажлын байр шинээр нэмэгдлээ.</li> <li>❖ Сав баглаа боодлын “Алтан жирэм”, “Мөнгөн пластик” зэрэг компаниуд сав баглаа боодлын үйлдвэрийн техник технологио шинэчлэн ажлын байр нэмэгдүүлээд байна.</li> <li>❖ Орон нутгийн үйлдвэр аж ахуйн нэгжүүдэд сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр сав баглаа боодлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр 3 аймгийн 4 аж ахуйн нэгжид 172,8 сая төгрөгийн зээл олгогдсон.</li> </ul>
--	---

Үнэлгээ:100

**2.4 Бага оврын хэвлэлийн техник, сэлбэг хэрэгслийн үйлдвэрийг бүсийн төвүүдэд байгуулах;**


❖ Хэвлэлийн туслах материалын хэрэглээ, бага оврын үйлдвэрлэл, бага оврын тоног төхөөрөмжийн үйлдвэр байгуулах боломжийн судалгааг БНХАУ-аас импортоор авч ашигладаг 20 орчим нэр төрлийн туслах материалын үйлдвэрийн шат дамжлага тус бүрээр төрөлжүүлэн хийсэн. Судалгаагаар хэвлэлийн туслах материал, хэвлэлийн хавтан, хавтан зайлах шингэн, хэвлэлийн машины будгийн болон усны бул угаах шингэн, хэвлэлийн будгийн пигментийг холин пантон өнгийн будаг найруулах үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулах боломжтой ба хэвлэлийн тоног төхөөрөмжөө 100 % импортоор авдаг байна. Манай орны тухайд цаас зүсэгч, кальк тодруулагч, цаас нугалагч, цаасны горив гаргагч, бүрэгч, нэрийн хуудас зүсэгч машин зэрэг зарим бага оврын төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэн ашиглах боломжтой гэсэн дүгнэлт гарсан.

❖ Эдгээр бага оврын тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэх үйлдвэрлэлийн төсөл боловсруулан “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрт тусгуулаад байна.

❖ Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд тогтмол өсөж байгаа бөгөөд 2012 оны байдлыг 2016 онтой харьцуулахад үйлдвэрлэлийн хэмжээ 12 %-иар өссөн байна.

он	Цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл /сая төгрөгөөр/	Целлюлоз, цаас, картон, тэдгээрээр хийсэн зүйлийн импорт /мян.\$/	Целлюлоз, цаас, картон, тэдгээрээр хийсэн зүйлийн экспорт /мян.\$/
2011	10567	65035	35.5
2012	14083	5877	61.0
2013	13002	65311	53.8
2014	15654	55240	55.4
2015	15824	45957	105.7
2016	1563	47250	73.0


Мэдээллийн эх үүсвэр: Статистик эмхэтгэл



Мэдээллийн эх үүсвэр: Статистик эмхэтгэл болон Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас хийсэн SWOT шинжилгээ болон хэрэглэгчийн зах зээлийн судалгаа

❖ Тус салбар нь дотооддоо хэвлэмэл бүтээгдэхүүнээ 100% үйлдвэрлэх хүчин чадал суурилагдсан, хүчин чадлын 70%-ийг ашиглан хэвлэмэл бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээний 92 % үйлдвэрлэж байгаа бөгөөд хууль эрх зүйн таатай орчин бүрдсэн нөхцөлд экспортлох боломжтой гэсэн судалгаа гарсан.

Хэрэглэгчийн зан төлөв байдлын судалгаагаар манай бүтээгдэхүүнийг хэрэглэгчид бүтцийг харуулбал:

		 <p>Цахим мэдээллийн ертөнц дэлгэрснээр хэвлэл, мэдээллийн салбарын зах зээлийн нөхцөл байдал, эрэлт нийлүүлэлтэд хэрэглэгчийн зан төлөвт эерэг ба сөрөг нөлөөллийг үзүүлсээр байна.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:100</b></p>																																																																
	<p><b>Зорилт-3:</b>  <b>Шинэ дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэх</b></p> <p><b>Хүрэх үр дүн1:</b>                  Салбарын техник технологийн түвшин олон улсын жишигт хүрсэн байх,</p>	<p><b>3.1. Хэвлэлийн техник, технологи, машин, тоног төхөөрөмжийг лизингээр олгох нөхцөлийг бүрдүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх;</b>                  2009-2016 онуудын хэвлэл, сав баглаа боодлын салбарын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, татварын хөнгөлөлт, олгосон хөнгөлөлттэй зээл</p> <table border="1" data-bbox="614 884 1492 1288"> <thead> <tr> <th rowspan="2">Он</th> <th colspan="2">Хөнгөлөлттэй зээл авсан</th> <th colspan="2">Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт</th> <th rowspan="2">Гааль, НӨАТ хөнгөлөлтийн дүн /сая ₮/</th> </tr> <tr> <th>ААН-ийн тоо</th> <th>Хэмжээ /сая төг/</th> <th>ААН-ийн тоо</th> <th>Хэмжээ /сая төг/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2009</td> <td>6</td> <td>218,0</td> <td>9</td> <td>422,3</td> <td>65,4</td> </tr> <tr> <td>2010</td> <td>23</td> <td>788,0</td> <td>26</td> <td>8076,0</td> <td>1130,4</td> </tr> <tr> <td>2011</td> <td>21 аан, 12 иргэн</td> <td>5218,4</td> <td>31</td> <td>7478,7</td> <td>1159,2</td> </tr> <tr> <td>2012</td> <td>24</td> <td>5300,0</td> <td>200*</td> <td>34964,5</td> <td>5419,5</td> </tr> <tr> <td>2013</td> <td>6</td> <td>1693,6</td> <td>160*</td> <td>30585,6</td> <td>4740,7</td> </tr> <tr> <td>2014</td> <td>13</td> <td>12045,0</td> <td>80*</td> <td>17436,3</td> <td>2702,6</td> </tr> <tr> <td>2015</td> <td>6</td> <td>1711,8</td> <td>98</td> <td>9648,9</td> <td>1495,6</td> </tr> <tr> <td>2016</td> <td>-</td> <td>-</td> <td>2</td> <td>2 тэрбум</td> <td>299,2</td> </tr> <tr> <td><b>ДҮН</b></td> <td><b>111</b></td> <td><b>26974,8</b></td> <td><b>606*</b></td> <td><b>110612,3</b></td> <td><b>17012,6</b></td> </tr> </tbody> </table> <p>*- давхардсан тоогоор, Мэдээллийн эх үүсвэр:ЖДҮДС-гийн Зээлийн мэдээллийн сан, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ 2016 онд хэвлэл, сав баглаа боодлын үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд техник тоног төхөөрөмжөө шинэчлэх, үйлдвэрлэлээ өргөтгөх зорилгоор ЖДҮХС-аас 2 аж ахуйн нэгжид 2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.</li> <li>❖ Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн 2009 оноос хойш 111 аж ахуйн нэгжийг экспортыг дэмжих, импортыг орлох, Жижиг Дунд Үйлдвэрийг дэмжих сангийн зээлэнд хамруулж 26974,8 сая төгрөгийн зээл олгосон байна.</li> <li>❖ Мөн 2009 оноос хойш 606 аж ахуйн нэгж 110612,3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийж /эргэлтийн хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгийн/ хөрөнгө оруулалтыг тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын 25 %-иар тооцоход -27153,0 сая ₮/ нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 137586,3 сая төгрөгт хүрч хөтөлбөрт төлөвлөснөөр 17012,4 сая төгрөгийн гааль, НӨАТ хөнгөлөлт үзүүлсэн байна.</li> <li>❖ Эдгээр зээл, тусламжийн үр дүнд олон улсын жишигт хүрсэн дараах технологүүд хэвлэлийн салбарт нэвтэрсэн байна:             <ul style="list-style-type: none"> <li>➢ Дэлхийд тэргүүлж буй Японы, Герман, Швейцарийн хэвлэлийн тоног төхөөрөмжүүдийг салбарын үйлдвэрүүдэд нутагшуулж, хэвлэмэл бүтээгдэхүүний чанар дэлхийн жишигт хүрэх нөхцөл бүрдсэн.</li> <li>➢ 2010 онд сав баглаа боодлын эко үйлдвэр “Эко Пак</li> </ul> </li> </ul>	Он	Хөнгөлөлттэй зээл авсан		Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт		Гааль, НӨАТ хөнгөлөлтийн дүн /сая ₮/	ААН-ийн тоо	Хэмжээ /сая төг/	ААН-ийн тоо	Хэмжээ /сая төг/	2009	6	218,0	9	422,3	65,4	2010	23	788,0	26	8076,0	1130,4	2011	21 аан, 12 иргэн	5218,4	31	7478,7	1159,2	2012	24	5300,0	200*	34964,5	5419,5	2013	6	1693,6	160*	30585,6	4740,7	2014	13	12045,0	80*	17436,3	2702,6	2015	6	1711,8	98	9648,9	1495,6	2016	-	-	2	2 тэрбум	299,2	<b>ДҮН</b>	<b>111</b>	<b>26974,8</b>	<b>606*</b>	<b>110612,3</b>	<b>17012,6</b>
Он	Хөнгөлөлттэй зээл авсан			Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт		Гааль, НӨАТ хөнгөлөлтийн дүн /сая ₮/																																																												
	ААН-ийн тоо	Хэмжээ /сая төг/	ААН-ийн тоо	Хэмжээ /сая төг/																																																														
2009	6	218,0	9	422,3	65,4																																																													
2010	23	788,0	26	8076,0	1130,4																																																													
2011	21 аан, 12 иргэн	5218,4	31	7478,7	1159,2																																																													
2012	24	5300,0	200*	34964,5	5419,5																																																													
2013	6	1693,6	160*	30585,6	4740,7																																																													
2014	13	12045,0	80*	17436,3	2702,6																																																													
2015	6	1711,8	98	9648,9	1495,6																																																													
2016	-	-	2	2 тэрбум	299,2																																																													
<b>ДҮН</b>	<b>111</b>	<b>26974,8</b>	<b>606*</b>	<b>110612,3</b>	<b>17012,6</b>																																																													

		<p>Монгол”ХХК байгуулан дотоодын зах зээлд 30 орчим нэр төрлийн савлагааны бүтээгдэхүүн нийлүүлж байна</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Дэлхийн өндөр технологийн хэвлэх машин RYOBИ 928 ашиглан офсет хэвлэлийн 5С-7С хэвлэлт нэвтэрсэн байна.</li> <li>➤ PANOBOOK хэвлэлт солонгорлолттой хэвлэлийн технолгийг 10 гаруй үйлдвэрүүд хэвлэж байна.</li> <li>➤ 3D метал хэвлэлт/төмөр, хуванцар, мод, шилэн дээрх хэвлэлтийг 40 орчим үйлдвэрүүд хэвлэж байна.</li> <li>➤ Хамгийн том А1 форматаар хэвлэж байна.</li> </ul> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 100</i></p> <p><b>3.2.Хэвлэлийн үйлдвэрийн технологийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Дэлхийд тэргүүлж буй Японы, Герман, Швейцарийн хэвлэлийн тоног төхөөрөмжүүдийг салбарын үйлдвэрүүдэд нутагшуулж, хэвлэмэл бүтээгдэхүүний чанар дэлхийн жишигт хүрэх нөхцөл бүрдсэн.</li> <li>❖ Мөнхийн үсэг” ХХК 2010 онд сав баглаа боодлын эко үйлдвэр-“Эко Пак Монгол”ХХК байгуулан дотоодын зах зээлд 30 орчим нэр төрлийн савлагааны бүтээгдэхүүн нийлүүлж байна. Дэлхийн өндөр технологийн хэвлэх машин RYOBИ 928 ашиглан офсет хэвлэлийн 5С-7С , PANOBOOK хэвлэлт, 3D метал хэвлэлт болон монголдоо хамгийн том А1 форматаар хэвлэж байна. Мөн 2016 онд чанар, үр ашгийн хамгийн өндөр үнэлгээ бүхий “<b>Азийн бүтээмжийн загвар</b>” байгууллагаар шалгарсан байна.</li> <li>❖ БНХАУ-н Хэвлэлийн технологийн их сургуультай холбоо тогтоож, ШУТИС-ҮТС-тай оюутан солилцоо хийх, оюутны дадлага хийлгэх, багш эрдэмтэдээр лекц уншуулах зэрэг хэлбэрээр хамтран ажиллах урьдчилсан тохиролцоонд хүрч, энэ асуудлаа ШУТИС-н гадаад харилцааны албанд танилцуулан ажиллав.</li> <li>❖ Япон, Солонгос, Тайланд, БНХАУ-н хэвлэлийн холбоодтой хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, 2015 онд Германы Салмандр фирмийн төлөөлөгч, ОХУ дахь суурин төлөөлөгч Глеб Газухин нартай уулзаж, хамтын ажиллагааны талаар санал солилцож, Мөнхийн Үсэг ХХК, Финпак ХХК зэрэг компаниудын үйлдвэрүүдийг танилцуулсан.</li> <li>❖ 2016 онд БНСУ, БНХАУ-н Хэвлэлийн холбоо, Японы SYBER корпорацийн удирдлага, төлөөлөгчдийг хүлээн авч салбарын хөгжил, МХҮХ-ны үйл ажиллагааг танилцуулж, санал солилцов.</li> <li>❖ 2016 онд БНХАУ, БНСУ, ХБНГУ-д зохиогдсон хэвлэлийн техник, технологийн Олон улсын үзэсгэлэн худалдааны зохион байгуулагчидтай холбоо тогтоон, хэвлэлийн үйлдвэрийн захиралуудын багийг тусгай хөтөлбөр программтайгаар оролцуулсан. Үзэсгэлэн үзэж сүүлийн үеийн техник, технологийн дэвшил, чиг хандлагын талаар мэдээлэл авах, худалдааны гэрээ байгуулах, сургалт судалгааны байгууллага, үйлдвэрүүдээр орж танилцах уулзалт хийлээ.</li> <li>❖ Жил бүр уламжлал болон зохиогддог “Монгол үйлдвэрлэв-Цагаан сар”, Шинэ жил”, “Номын баяр”, “Их хотын хямдрал”, 2016 онд болсон “Монгол брэнд- АСЕМ” зэрэг үзэсгэлэн худалдаанд салбарын үйлдвэрүүд идэвхтэй оролцож дундажаар нийт 2-3 сая төгрөгийн борлуулалт хийж 10-20 үйлдвэрлэгчид тогтмол оролцдог болоод байна.</li> <li>❖ Арьс ширний холбоо, Ноос ноолуурын холбоодтой хамтран Мишээл Экспо төвд Үзэсгэлэн худалдаанд 10 үйлдвэрлэгчид оролцож 5 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</li> </ul> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ:90</i></p> <p><b>3.3.Хэвлэлийн судалгаа, шинжилгээ хийх, чанарын хяналтын</b></p>
--	--	--



	<p><b>лаборатори байгуулах;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Хэвлэмэл бүтээгдэхүүн будаг, бодис, техникийн аюулгүй байдал хэрэглэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх болон бусад туслах материалын үйлдвэрлэл байгуулах, хэвлэлийн судалгаа, шинжилгээ хийх, чанарын хяналтыг сайжруулах лаборатори байгуулах, техникийн засвар үйлчилгээний сүлжээ бий болгох зэрэг арга хэмжээг төслийн 2-р шатанд 500,0 сая төгрөг төвлөсөн боловч мөн санхүүжилт дутмаг байдлаас хамааран зөвхөн судалгааны хүрээнд ажлууд хийгдсэн. Уг төслийг Азийн хөгжлийн банкны хөгжлийг дэмжих төсөлд 2016 оны 11 сард өгч танилцуулагдсан.</li> <li>❖ Мөн хэвлэлийн үйлдвэрлэлийг үйлдвэрлэл технологийн паркаар хөгжүүлэх тухай үр дүн үр ашгийн тооцоо, судалгаа хийх 20,0 сая төгрөгийн санхүүжилтийг 2018 оны улсын төсөвт тусгуулсан байна.</li> </ul> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:50</b></p> <p><b>3.4. Техникийн засвар үйлчилгээний сүлжээ бий болгох;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Хэвлэлийн бага оврын техник хэрэгсэлийн засвар үйлчилгээний төв байгуулж, гадагшаа гарах мөнгөний урсгалыг тогтоох, мэргэшсэн засвар үйлчилгээний ажилтнууд сурган дадлагажуулах улмаар орон нутагт уг сүлжээг бий болгох талаар тодорхой арга хэмжээ төлөвлөн ажилласны дүнд мэргэжлийн холбоо, үйлдвэрлэгчдээс 2-3 төсөл боловсруулагдан жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санд танилцуулахаар бэлтгээд байна.</li> <li>❖ Энэ хүрээнд мэргэжлийн холбоо, хувийн хэвшил үйлдвэрлэгчдээс ирсэн Техник засвар үйлчилгээний төв байгуулах төсөл, Хэвлэлийн үйлдвэрлэлийг паркаар хөгжүүлэх боломжийн тухай судалгаа хийх төсөл, Орон нутагт техник засвар үйлчилгээний сүлжээ төв байгуулах зэрэг 3 төслийг боловсруулан Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих санд танилцуулахаар бэлтгээд байна.</li> <li>❖ Техник, тоног төхөөрөмж болон цаасан түүхий эдийн хараат байдлыг багасгах үүднээс хэвлэлийн бага оврын техник хэрэгсэлийн засвар үйлчилгээний төв байгуулах, гадагшаа гарах мөнгөний урсгалыг тогтоох, мэргэшсэн засвар үйлчилгээний ажилтнууд сурган дадлагажуулах улмаар орон нутагт уг сүлжээг бий болгох арга хэмжээг хөтөлбөрийн 2 дугаар шатны төлөвлөгөөнд тусгагдсан боловч санхүүгийн хүртээмжгүй байдлаас шалтгаалан хэрэгжилт тасалдсан болно.</li> </ul> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:70</b></p> <p><b>3.5.Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн дэвшилтэт технологийг нутагшуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авч хөнгөлөлттэй зээлд хамруулах.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Сав баглаа боодлын “Эко Пак Монгол”ХХК 2010 онд 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгуулагдснаас 300 сая төгрөг нь хөнгөлттэй зээл байсан. Хоногт 80-100 мянган.ш хайрцаг үйлдвэрлэх хүчин чадалтай, хүний биед хоргүй, байгаль орчинд ээлтэй эко үйлдвэр 30 орчим нэр төрлийн савлагааны бүтээгдэхүүн нийлүүлж өндөр үр ашигтай ажиллаж байна.</li> <li>❖ Битпрес, Адмон, Арилдал, Бембисан зэрэг 6 компани ХБНГУ-ын “HEIDELBERG“, Япон улсын “RYOBI4“, “КВА” фирмийн 4 өнгийн өндөр технологийн хэвлэлийн машиныг бас нэмэлт өнгө лакны 4-6 хүртэл хийдэг 5С-7С технологийг нэвтрүүлээд байна.</li> <li>❖ PANOBOOK хэвлэлт буюу солонгоролттой 3D метал хэвлэлт хэд хэдэн томоохон үйлдвэрүүд нэвтрүүлсэн. Адмон, Интерпресс Бемби сан ХХК компаниуд номын блокыг 3 талаас нь алтдах , “Интерпресс”, “Хур ном” зэрэг 5 компаниуд хусаж арилгадаг</li> </ul>
--	---

		<p>/нэгжийн карт гэх мэт/ технологийг, Мөнхийн үсэг ХХК Адмон ХХК зэрэг 3 үйлдвэр үнэт цаас, нууцлалтай саналын хуудас хэвлэх зэрэг дэвшилтэт технологийг тус тус нэвтрүүлсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Монголдоо хамгийн том А1 форматаар ( А-1 хэмжээс 100 см*70 см) Мөнхийн үсэг, Адмон, Интэрпресс зэрэг 3 үйлдвэр хэвлэж байна.</li> <li>❖ Үнэт цаасны тусгай нууцлалтай өндөр технологи нэвтрэн бензин талон, хэвлэмэл картууд, саналын хуудас зэргийг хурдтай олон тоогоор 3 үнэт цаасны үйлдвэр нийлүүлсэн.</li> <li>❖ Япон, Солонгос, Тайланд, БНХАУ-н хэвлэлийн холбоодтой хамтын ажиллагаатай ажиллаж, шинээр Германы Салмандр фирмийн төлөөлөгч, ОХУ дахь суурин төлөөлөгч Глеб Газухин нартай уулзаж, хамтын ажиллагааны талаар санал солилцож, Мөнхийн Үсэг ХХК, Финпак ХХК зэрэг компаниудын үйлдвэрүүдийг танилцуулан ажиллав.</li> <li>❖ 2016 онд БНСУ, БНХАУ-н Хэвлэлийн холбоо, Японы SYBER корпорацийн удирдлага, төлөөлөгчдийг хүлээн авч салбарын хөгжил, МХҮХ-ны үйл ажиллагааг танилцуулж, санал солилцов.</li> <li>❖ БНХАУ, БНСУ, ХБНГУ-д зохиогдсон хэвлэлийн техник, технологийн ОУ-н үзэсгэлэн худалдааны зохион байгуулагчидтай холбоон тогтоон, хэвлэлийн үйлдвэрийн захирлуудын багийг тусгай хөтөлбөр программтайгаар оролцуулсан. Үзэсгэлэн үзэж сүүлийн үеийн техник, технологийн дэвшил, чиг хандлагын талаар мэдээлэл авах, худалдааны гэрээ байгуулах, сургалт судалгааны байгууллага, үйлдвэрүүдээр орж танилцах уулзалт хийсэн зэрэг нь манай салбарын гадаад хамтын ажиллагаа болон технолги шинэчлэлд тодорхой үүрэг гүйцэтгэж байна.</li> </ul> <p style="text-align: right;">❖ <i>Үнэлгээ: 100</i></p>
		<i>3 дугаар зорилтын дундаж үнэлгээ:</i>
	<p><b>4-р зорилт:</b>  <b>Орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх Томоохон суурин газруудад хэвлэлийн үйлдвэр, үйлчилгээний цэгүүд байгуулагдсан байх,</b></p> <p><i>Хэвлэлийн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтүүд;</i></p>	<p><b>4.1. Ном, хэвлэлийн бүтээгдэхүүн, түүхий эд, материалыг орон нутагт хүргэх, түгээх сүлжээг байгуулах;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Монголын хэвлэлийн үндэсний холбооны гишүүн байгууллагууд үнийн нэгдсэн бодлогын талаар санал солилцох уулзалт зохион байгуулж үнэ бодох томъёоллоо хэлэлцэж тогтсон байна.</li> <li>❖ Ном өдөр тутмын сонин сэтгүүлийн нэгдсэн сүлжээг өргөтгөж, улмаар түгээлт хүргэлтийг хугацааг цаг алдалгүй хөнгөн шуурхай болгох чиглэлээр сонингийн үйлдвэрлэлийн томоохон үйлдвэр болох “Чөлөөт хэвлэлийн сан”, “Өдрийн сонин”, “Засгийн газрын мэдээ” нь нийлж орон нутгийн хэвлэлийн салбарынхны нэгдсэн сургалт хийж хийсэн ажлаа тайлагнав.</li> <li>❖ Дархан, Эрдэнэт, Сэлэнгэ зэрэг хүн амын нягтаршил ихтэй аймагуудад хэвлэлийн болон бусад түргэн үйлчилгээний цэгүүдийн тоо нэмэгдэж, 2007 оны суурь түвшинтэй харьцуулахад 80% нэмэгдсэн байна.</li> <li>❖ Хэвлэлийн үйлдвэрүүдийн байршлын судалгааг гаргаж, нэгдсэн тойм зураглал гаргав. Өнөөгийн байдлаар Монгол улсын хэмжээнд Улаанбаатар хотод 210 орчим, хөдөө орон нутагт 80 орчим аж ахуйн нэгж хэвлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, 3500-4000 орчим хүнийг ажлын байраар хангаж байна.</li> <li>❖ 2009-2016 Мулзи пак, Монос кан байгуулагдаж хэвлэлийн үйлдвэрлэлийн дотоодын хэрэгцээний 95 % үйлдвэрлэж байна. 2016 оны хэвлэмэл бүтээгхүүний орлого 2010 оны мөн үетэй харьцуулахад 189,3% өссөн дүнтэй байна.</li> <li>❖ Хэвлэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн бүртгэлээр ЖДҮ хөгжүүлэх болон орон нутгийн хөгжлийн сангийн зээл тусламжаар нийт 604 аж ахуй нэгжид 108612,3 сая төг зээл авч үйл ажиллагаагаа</li> </ul>

		<p>өргөжүүлсэн байна.</p> <p>❖ Хөдөө орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн бүртгэлээр 21 аймагт 90 орчим хэвлэл, үйлчилгээний цэгүүд ажиллаж, орон нутгийн хэрэгцээний захиалгын 60-70% үйлдвэрлэдэг болсон.Орон нутагт сонин үйлдвэрлэх, ном хэвлэлийн түгээлт, борлуулалтын сүлжээг бий болгох зорилгоор томоохон хэвлэлийн үйлдвэрүүд Сэлэнгэ, Дархан, Эрдэнэт хотод салбараа нээн ажиллуулж байна.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:90</b></p> <p><b>4.2.Хэвлэлийн үйлдвэрлэл орон нутагт шинээр байгуулах, технологийн шинэчлэл хийх төслийг хөнгөлөлттэй зээлд хамруулах</b></p> <p>❖ Хөдөө орон нутаг, томоохон суурин газруудад хэвлэл үйлдвэр, үйлчилгээний цэгүүд олноор байгуулагдаж байгаа ба 21 аймагт 2007 онд 50 орчим үйлчилгээний цэг байсан бол 2016 оны 9 сарын байдлаар 90 хэвлэл жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цэгүүд үйл ажиллагаа явуулж байна. Аймаг орон нутагт зах зээлийн багтаамжаас хамааран жижиг,үйлдвэрлэл үйлчилгээ, өрхийн үйлдвэрлэл түлхүү хөгжиж байна</p> <p>❖ Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Ах трейд” ХХК, “Тэнгэр баатар” ХХК, Сэлэнгэ принтинг ХХК, Мандал сумын “Деклаян” ХХК-иуд аймгийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хулдаасан хэвлэл хийж, орчин үеийн шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийт хэвлэмэл бүтээгдэхүүний 63 %-ийг хангаж 20-аад сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Тус аймгийн сум хөгжүүлэх сангаас хулдаасан хэвлэлийн машин, тоног төхөөрөмж авахад зориулж 30,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.</p> <p>❖ Монголын хэвлэлийн үндэсний холбооны нь Орхон, Дархан-Уул, Баянхонгор, Увс, Ховд аймгуудийн хэвлэлийн салбарынхантай холбоо тогтоож, уулзаж санал солилцон нутгийн хэвлэлийн үйлдвэрүүдэд тулгамдаж байгаа асуудлуудыг тогтоон Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, боловсон хүчин, ялангуяа хэвлэгчийг богино хугацааны сургалтаар бэлтгүүлэх, ур чадвар ахиулах сургалтанд хамруулах зэрэгт дэмжлэг үзүүлэх шийдвэр гарган хэрэгжүүлсэн.</p> <p>❖ Сэлэнгэ аймагт 5 сумын 6 иргэнд 34,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор хэвлэлийн үйлчилгээний 6 цэг шинээр нээсэн байна.</p> <p>❖ Сүхбаатар сумын иргэн Намжилмаа сум хөгжүүлэх сангаас 4,0 сая төгрөгийн зээл авч номын дэлгүүр байгуулан Аз хур ХХК-тай гэрээ байгуулан ном хэвлэл ард иргэдэд түгээх үйл ажиллагаа явуулан, сард 200,0-500,0 мянган төгрөгийн ашигтай ажиллаж байна.</p> <p style="text-align: center;"><i>Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байдал</i></p> <table border="1" data-bbox="614 1691 1476 1892"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2009</th> <th>2010</th> <th>2011</th> <th>2012</th> <th>2013</th> <th>2014</th> <th>2015</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Аж ахуй нэгжийн тоо</td> <td>6</td> <td>23</td> <td>21аан, 12 иргэн</td> <td>24</td> <td>6</td> <td>14</td> <td>6</td> </tr> <tr> <td>Зээлийн хэмжээ /сая төг/</td> <td>218.0</td> <td>788.0</td> <td>5218.4</td> <td>5300.0</td> <td>1693.6</td> <td>12045.0</td> <td>1711.8</td> </tr> </tbody> </table> <p>Мэдээллийн эх үүсвэр:ЖДУДС-гийн Зээлийн мэдээллийн сангаас, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:100</b></p>	Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	Аж ахуй нэгжийн тоо	6	23	21аан, 12 иргэн	24	6	14	6	Зээлийн хэмжээ /сая төг/	218.0	788.0	5218.4	5300.0	1693.6	12045.0	1711.8
Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015																			
Аж ахуй нэгжийн тоо	6	23	21аан, 12 иргэн	24	6	14	6																			
Зээлийн хэмжээ /сая төг/	218.0	788.0	5218.4	5300.0	1693.6	12045.0	1711.8																			
<b>5-р зорилт:Хэвлэлийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах</b>		<p><b>5.1. Хэвлэлийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлэх;</b></p> <p>❖ Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоо нь бодлого зохицуулалтын, мэргэжлийн, олон нийттэй харилцах, гадаад</p>																								

<p><i>Ажлын байрны өсөлт, бууралт, зорилтот сургалтын тоо, түүнд хамрагдсан хүний тоо;</i></p>	<p>харилцаа хариуцсан гэсэн 4 салбар зөвлөлийнхээ 2016 онд хийх ажлын ерөнхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Мэргэжлийн инженер техникийн ажилтан бэлтгэдэг ШУТИС-ын хэвлэлийн лабораторийн асуудлаар тус сургуулийн захиргаанд албан тоот илгээж, сургалтын техник тоног төхөөрөмжийн баазыг бэхжүүлэхэд хамтран ажиллахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.</li> <li>❖ Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн холбоо нь Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой офсет машины хэвлэгчийг Япон улсад гэрээгээр ажиллуулах хэлбэрээр дадлагажуулах, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэх төсөл бичиж хэрэгжүүлэх талаар тохиролцож төсөл боловсруулан Японы талд санал тавьсан боловч санхүүгийн эх үүсвэрээс шалтгаалан хойшлогдсон болно.</li> <li>❖ Хэвлэлийн холбоо нь гишүүн байгууллагууддаа чиглэл өгч, Монгол-Солонгосын Политехникийн коллеж, Шинэ иргэншил Мэргэжилийн сургалт үйлдвэрлэлийн хэвлэлийн эх бэлтгэл, тоног төхөөрөмжийн анги, ШУТИС-н дизайны ангийн оюутнуудыг дадлага хийх нөхцөл бололцоогоор хангаж ажилласнаар дадлага удирдах ажилтнууд тухайн сургууль дээр очиж дадлагажигчаа хүлээж авдаг, нэгдсэн журмаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар заавар зөвлөгөө өгүүлдэг зэрэг ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна.</li> <li>❖ Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт ажиллагсадын тоо 2007 онд 1800-2000 орчим байсан бол, 2016 оны эцсээр 4000 орчим болж өссөнөөс гадна, хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллагсад эзлэх хувь хэмжээ-7,8-11,8% хүртэл өссөн дүнтэй байна.</li> </ul> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:90</b></p> <p><b>5.2.Салбарын ажил, мэргэжлийн ангилал, мэргэжлийн үндсэн норматив, хөдөлмөрийн тарифыг шинэчлэн боловсруулах;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Монголын Хэвлэлийн холбоо нь ШУТИС-тай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, Төрийн өмчтэй хэвлэх үйлдвэрүүдийн судалгаа гаргах, “Хэвлэлийн тулгамдсан болон чухал асуудлаар” онол практикийн бага хурал хийх, "Хэвлэлийн дизайнч"-ийн АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ гаргах зэрэг ажлуудыг хийсэн байна. Мэргэжлийн инженер техникийн ажилтан бэлтгэдэг ШУТИС-ын хэвлэлийн лабораторийн асуудлаар тус сургуулийн захиргаанд албан тоот илгээж, сургалтын техник тоног төхөөрөмжийн баазыг бэхжүүлэхэд хамтран ажиллахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.</li> <li>❖ Монголын Хэвлэлийн холбоо нь Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой офсет машины хэвлэгчийг Япон улсад гэрээгээр ажиллуулах хэлбэрээр дадлагажуулах, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэх төсөл бичиж хэрэгжүүлэх талаар тохиролцож төсөл боловсруулж эхэлсэн.</li> <li>❖ Монголын Хэвлэлийн холбоо нь гишүүн байгууллагууддаа чиглэл өгч, Монгол-солонгосын Политехникийн коллеж, Шинэ иргэншил Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн хэвлэлийн эх бэлтгэл,тоног төхөөрөмжийн анги, ШУТИС-н дизайны ангийн оюутнуудыг дадлага хийх нөхцөл бололцоогоор хангаж ажилласнаар дадлага удирдах ажилтнууд тухайн сургууль дээр очиж дадлагажигчаа хүлээж авдаг, нэгдсэн журмаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар заавар зөвлөгөө өгүүлдэг ажлыг Монгол-солонгосын Политехникийн коллеж дээр хэрэгжүүлж эхэлсэн.</li> <li>❖ Хөдөлмөрийн яам, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой хамтран АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ гаргаж эхэлсэн.</li> <li>❖ Сэлэнгэ пресс ХХК, Хөх Монгол принтинг ХХК, Мөнхийн Үсэг ХХК зэрэг компаниуд Аж үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан</li> </ul>
--	--

Эдийн засгийн чуулган, Хөдөлмөрийн яамнаас зохион байгуулсан ХӨДӨЛМӨР-ХӨГЖЛИЙН ҮНДЭС чуулга уулзалт болон урлаг соёлын тоглолтуудыг ивээн тэтгэж хамтран зохион байгуулсан байна.

❖ Жил бүр уламжлал болон зохиогддог Монголын Хэвлэлийн холбооны нэрэмжит цомын төлөөх спортын 5 төрөлтийн тэмцээнийг Соёлын төв өргөөнд зохион байгуулсан.

❖ Монголын хэвлэлийн холбооноос Хэвлэлийн үйлдвэрүүдийн дунд шинэ жилийн тэмцээн зохион байгуулж орчин үеийн техник технологи нэвтрүүлэх чиглэлээр үр дүнтэй ажиллаж буй компани удирдах ажилтнуудыг төрийн шагналд тодорхойлж Мөнхийн Үсэг ХХК-ийн ЭБА дарга Т.Доржсүрэн Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Сэлэнгэ пресс ХХК-н захирал М.Болд Алтангадас одон, Арвай принт ХХК-ийн захирал Н.Сүрэнхорлоо Алтангадас одон, Ном Хур ХХК-н захирал Ч.Дүгэр Хөдөлмөрийн хүндэт медаль, хэвлэл сангийн ажилтан Р.Мөнхсайхан, Б.Энхтуяа, Д.Дөшгомбо, Яанкес Брор Иоким Яанкс нар аж үйлдвэрийн тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулсан байна.


*Үнэлгээ: 70*

**5.3.Хэвлэлийн үйлдвэрийн удирдах болон мэргэжлийн ажилтан бэлтгэх зорилгоор сургалт зохион байгуулж, үйлдвэр түшиглэсэн дадлагын төвийг ажиллуулах**

❖ Монголын хэвлэлийн холбооны гишүүн байгууллагат хэвлэлийн эх бэлтгэгч, хэвлэлийн дизайнераар бэлгэгдэж буй оюутан, дадлагажигчдыг өөрийн үйлдвэр дээр авч, дадлагажуулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар заавар зөвлөгөө өгүүлдэг зэрэг ажлыг хэрэгжүүлж эхэлсэн. Мөн Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой офсет машины хэвлэгчийг Япон улсад гэрээгээр ажиллуулах хэлбэрээр дадлагажуулах, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэх төсөл бичиж хэрэгжүүлэх талаар тохиролцож төсөл боловсруулсан.

❖ Монгол-солонгосын Политехникийн коллеж , Шинэ иргэншил Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн хэвлэлийн эх бэлтгэл,тоног төхөөрөмжийн анги, ШУТИС-н дизайны ангийн оюутнуудыг дадлага хийх нөхцөл бололцоогоор хангаж ажилласнаар дадлага удирдах ажилтнууд тухайн сургууль дээр очиж дадлагажигчаа хүлээж авдаг, нэгдсэн журмаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар заавар зөвлөгөө өгүүлдэг зэрэг ажлыг хэрэгжүүлж эхэлсэн.

❖ Спорт урлагийн нэгдсэн арга хэмжээг хэвлэлийн гишүүн байгууллагуудын дунд жил бүр зохион байгуулдаг болоод байна. Их дээд сургуулиудтай хамтран инжнер техникийн ажилтан бэлтгэх болон давтан сургалтыг 3-4 удаа зохион байгуулж, 150 орчим хүнийг хамруулсан.



		<p><i>Мэдээллийн эх үүсвэр: Статистик эмхэтгэл</i></p> <p>❖ Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт ажиллагсадын тоо 2007 онд 1800-2000 орчим байсан бол, 2016 оны эцсээр 4000 орчим болж өссөн, хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллагсадтай харьцуулхад хэвлэлийн үйлдвэрийн ажиллагсдын эзлэх хувь нь 7,8-11,8%-р өссөн дүнтэй байна.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:90</b></p>																
7	<p><b>Дүгнэлт:</b> (ололт, дутагдал, асуудлууд) анхаарах</p>	<p>Цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2007-2016 оны байдлаар, албан статистикийн мэдээгээр нэгтгэн харуулбал:</p> <table border="1" data-bbox="616 483 1490 680"> <thead> <tr> <th><i>Үзүүлэлт</i></th> <th>2007</th> <th>2008</th> <th>2009</th> <th>2011</th> <th>2013</th> <th>2014</th> <th>2015</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл /сая. төг/</td> <td>3127,6</td> <td>14218,4</td> <td>19771,8</td> <td>10567</td> <td>13002</td> <td>15654</td> <td>15824</td> </tr> </tbody> </table>	<i>Үзүүлэлт</i>	2007	2008	2009	2011	2013	2014	2015	Цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл /сая. төг/	3127,6	14218,4	19771,8	10567	13002	15654	15824
<i>Үзүүлэлт</i>	2007	2008	2009	2011	2013	2014	2015											
Цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл /сая. төг/	3127,6	14218,4	19771,8	10567	13002	15654	15824											
		<p><i>Мэдээллийн эх үүсвэр: Статистик эмхэтгэл</i></p> <p>➤ Төсөл хэрэгжих үеийн суурь түвшингийн үзүүлэлтээс харахад цаас, цаасан бүтээгдэхүүний 2007 онд 3127,6 сая төгрөг байсан бол, хэрэгжиж дуусах үе буюу 2016 оны цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 15630,0 сая төгрөг болж даруй 5 дахин нэмэгдсэн байна.</p> <p>➤ Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт ажиллагсадын тоо 2007 онд 1800-2000 орчим байсан бол, 2016 оны эцсээр 4000 орчим болж өссөн, хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллагсадтай харьцуулхад хэвлэлийн үйлдвэрийн ажиллагсдын эзлэх хувь нь 7,8-11,8%-р өссөн дүнтэй байна.</p> <p>➤ Аж ахуйн нэгж байгууллагуудын идэвхи санаачлага, хичээнгүй хөдөлмөрийн үр дүнд хэвлэлийн салбарын техник технологийн түвшин олон улсын жишигт тодорхой хэмжээгээр хүрсэн гэж үзэж болохоор байна.</p> <p>➤ Хэвлэлийн үйлдвэрүүдийн 90 хувь нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгааг анхааралдаа авч Үйлдвэр технологийн паркийн хүрээнд хэвлэл, сав баглаа боодлын үйлдвэрүүдийг нэгтгэн хорших, төрөлжихөд төрөөс дэмжлэг үзүүлбэл цаашид эрчимтэй хөгжих нөхцөл бүрдсэн байна.</p> <p>➤ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 удаагийн төлөвлөгөөнд тусгагдсан Улсын төсөвийн хөрөнгийн санхүүжилтийн дөнгөж 15,6 хувийг олгосон нь хөтөлбөрийн зорилтод арга хэмжээ бүрэн хэрэгжихэд нөлөөлсөн гэж үзэж байна.</p> <p>➤ Хэвлэлийн будаг, бодис болон бусад туслах материалын үйлдвэрлэл байгуулах, хэвлэлийн судалгаа, шинжилгээ хийх, чанарын хяналтыг сайжруулах лаборатори байгуулах, техникийн засвар үйлчилгээний сүлжээ бий болгох, нарийн мэргэжлийн ажилтан бэлтгэх зохион байгуулалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийн хэрэгжилт хангалтгүй байна.</p> <p>➤ Цаашид тус хөтөлбөрийн дутуу болон хэрэгжээгүй боловч зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг шаардагдах төсөв хөрөнгийг гаргуулах асуудлыг шийвэрлүүлэх талаар арга хэмжээ авч, Үйлдвэржүүлэх 21/100 хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхийг зөвлөж байна.</p>																

8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>➤ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран хэрэгжүүлэгч талууд тодорхой ажил хийгдсэн боловч тоо, судалгааг ирүүлэх талаар дутагдалтай байна.</p> <p>➤ Мөн аймаг, орон нутгийн дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн ажил тайланд төдийлөн харагдахгүй байна. Энэ нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага Засгийн газрын бүтцээр удаа дараа өөрчлөгдөж хийсэн ажлын мэдээллийн эх үүсвэр үнэгүйдэж байсантай холбоотой гэж үзэж байна.</p>						
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн төгсгөлийн шатны үнэлгээ (хувиар)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
		89,0	5	100	85	82	95	83,3
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ						
		.....%						